

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС 2022

Мониторингийн тайлан



“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2022: Мониторингийн тайлан”-г IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн санаачилгаар 11 дэх жилдээ хийж гүйцэтгэв.

Мониторингийн тайлангийн үр дүнг ашиглах бол эх сурвалжийг дурдана уу.

IRIM. Цахим ил тод байдлын индекс, УБ., 2022

Мониторингийн баг

Хүрэлчулуун Баярмаа
Ахлах судлаач

Баянбат Шинэцэцэг
Зохицуулагч, Судлаач





Тогтохбаяр Азбилэг
Инновац, технологийн менежер

Эх бэлтгэл, дизайн

Тогтохбаяр Азбилэг
Инновац, технологийн менежер

Ганбаатар Даваа
Судлаач/Зохицуулагч

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ СУДАЛГААНЫ ӨМНӨХ ТАЙЛАНГУУД



* Зураг бүр дээр дарж тайлан тус бүртэй танилцах боломжтой. Нийт тайлан: <http://irim.mn/web-monitoring>

АГУУЛГА

Удиртгал	5
1. Арга зүй	7
1.1. Индексийн зорилго, зорилт	7
1.2. Индексийн хүрээ	8
1.3. Индексийн бүтэц ба хэмжих аргачлал	11
2. Үр дүн	13
2.1. Нэгдсэн үр дүн	13
2.1.1. Цахим ил тод байдлын өөрчлөлт	13
2.2. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн	14
2.2.1. Мэдээллийг ил тод болгох бодлогын орчны нөхцөл байдал	15
2.2.2. Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох чадамж, бэлэн байдал	17
2.2.3. Цахим мэдээллийн нээлттэй байдал	19
2.3. Байгууллагуудын үр дүн	22
3. Дүгнэлт, зөвлөмж	23
Хавсралт 1. Арга зүй: Хэмжих индикаторууд, харгалзах оноо	25
Хавсралт 2. Байгууллагын төрөл тус бүрийн эрэмбэ	26
Хавсралт 3. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ	30

Удиртгал

Нийгмийн салбар бүрд мэдээлэл, харилцаа, холбооны технологи (МХХТ)-ийн дэвшилд дасан зохицох, нийцэх сорилт тулгарч байгаа бөгөөд ялангуяа төрийн байгууллагад инновацын өөрчлөлтүүд дутагдаж байгаа төдийгүй хамгийн удаан нэвтэрч байна. МХХТ-ийн хөгжлийн хамгийн чухал хэсэг нь газар зүйн байршлаас үл хамааран төрийн байгууллагын ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг сурталчлахад хувь нэмэр оруулах явдал бөгөөд нөгөөтээгүүр иргэд болон оролцогч талууд төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг МХХТ ашиглан нэмэгдүүлэхийг шаардаж буй юм. Тиймээс цахимаар хүргэж буй төрийн мэдээллийн ил тод байдал хэр байгааг хэмжиж, үр дүнг илүү сайжруулах шаардлага үүсээд байна.

НҮБ-аас цахим засаглал нэр томъёонд тулгуурлан анх МХХТ-ийн хөгжил дэвшлийг төрийн удирдлагад нэвтрүүлэх ажлыг эрчимтэйгээр зохион байгуулж, улс орон бүрд энэ чиглэлд тусламж, дэмжлэг үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2002 оноос хойш 'Цахим засаглалын хөгжлийн индекс'-ийг дэлхийн бүх улс орныг хамруулан тогтмол тооцож ирсэн. Уг индексэд 2022 онд Дани Улс 0.9717 үнэлгээтэйгээр тэргүүлж, Финланд, БНСУ удаалжээ. Хоёр жил тутамд гардаг энэ индексээр Монгол Улс 2016 онд 84, 2020 онд 92, 2022 онд 74 дүгээр байрт оржээ. Ингэснээр Монгол Улс хамгийн өндөр үзүүлэлт ахисан 4 орны нэгээр онцлогдон, 18 байр урагшилсан байна.

Монгол Улсад МХХТ ашиглан төрийн мэдээлэл, үйлчилгээг хүргэх үндэс суурь нь МУЗГ-ын МХХТ-ийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012) стратеги, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийг 2004 онд баталснаар тавигдсан. Хөтөлбөрийн хүрээнд "Цахим Засгийн мастер төлөвлөгөө" боловсруулж, цахим засгийг хэрэгжүүлэх, иргэндээ хандсан, нэг цэгийн, үр дүнтэй, хэмнэлттэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн. Энэ зорилгыг хангахын тулд дэвшүүлсэн зорилтын нэг нь байгууллага бүр цахим хуудастай, иргэн бүр цахим шуудангийн хаягтай болж, төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан онлайн горимоор хүргэх явдал байв (IRIM, 2012). Түүнчлэн Засгийн газрын 2008 оны 143-р тогтоолоор "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг баталж, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах тодорхой мэдээллийг албан ёсны цахим хуудаст байршуулахаар заасан нь төрийн мэдээлэл нийтэд нээлттэй байх үндэс суурь болсон юм. Тус тогтоол 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн Хоёрдугаар бүлэг болон батлагдаж, 2022 он хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор IRIM судалгааны хүрээлэн 2010-2011 онд төрийн цахим ил тод байдлыг хэмжих анхны арга зүйг боловсруулж, 2014 оноос хойш жил бүр тогтмол хэмжиж ирсэн. Хуулийн мониторингд суурилсан тус арга зүйг 2018 он хүртэл хэрэглэж, 2019 онд шинэчлэн, эрх зүйн орчин болон байгууллагын чадамж гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэг шинээр нэмж, олон улсад ашиглагдаж болохуйц төрийн байгууллагын "Цахим ил тод байдлын индекс"-ийг боловсруулж, анхны туршилтыг Монгол болон Киргизстан Улсад амжилттай туршиж байсан юм.

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас цахим засаглалыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг идэвхжүүлж, хариуцах шинэ бүтцийг бий болгож, дагалдах зарим томоохон бодлого, арга хэмжээг шинээр баталж, хэрэгжүүлж байна. Үүний нэг илрэл нь иргэд төрийн мэдээллийг авах эрхийг хангасан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 оны 12-р сард баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон. Тус хуульд өмнөх хуулийн агуулга багтахас гадна тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран өөр нэмэлт мэдээллүүдийг тусгах шаардлагатай болсон нь нэг талаар илүү өргөн хүрээний мэдээлэлд мониторинг хийх шаардлагыг үүсгэж байна.

Ийнхүү шинэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бид цахим ил тод байдлыг хэмжих арга зүйд дахин шинэчлэлтүүдийг хийх шаардлага тулгарсан юм. Тиймээс 2022 онд цахим ил тод байдлын индексийн арга зүйд зарим томоохон өөрчлөлтүүдийг хийж, эхний үр дүнгээ тооцлоо. Хэдийгээр арга зүйд шинэчлэлтүүд хийгдсэн боловч ерөнхий хүрээг өөрчлөөгүй тул өмнөх онуудтай харьцуулагдах байдлыг алдагдуулаагүй. Нөгөөтээгүүр, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу тус мониторингийн шалгуур үзүүлэлт болон тооцооллын арга зүйд зарим шинэчлэлүүд оруулсан тул уг судалгаа нь шинэ хуулийн хэрэгжилтийн суурь түвшнийг тодорхойлж буйгаараа онцлогтой юм.

1. Арга зүй

1.1. Индексийн зорилго, зорилт

Индекс нь төрийн байгууллагуудын мэдээллийн цахим ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид Засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой. Энэ зорилгын хүрээнд дэвшүүлсэн мониторингийн гол зорилтууд нь:

- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах

Индексийн үр дүнд тулгуурлан байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэх боломжийг олгохын тулд харьцуулсан дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Цаашид уг индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож байна.

Индексийн үр дүнг тооцон гаргахдаа дараах төрийн байгууллагуудыг жил бүр хамруулдаг (Зураг 1).

2021 онд эдгээр 6 төрлийн байгууллагын нийт тоо 88 байсан бол 2022 онд 93 болсон нь байгууллагуудын чиг үүрэг улам нарийсаж, салбарлаж байгааг харуулж байна.

ЗУРАГ 1

Төрийн мэдээллийн цахим ил тод байдлыг тооцон гаргахад хамруулсан байгууллагууд



1.2. Индексийн хүрээ

Ил тод байдлыг тогтвортой хэрэгжүүлснээр авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Иргэд мэдээлэлтэй байвал илүү хүчирхэг эрх мэдэлтэй байж, ардчилал, хүний эрхийг сайжруулахад сайн засаглалыг бэхжүүлэх суурь итгэл үнэмшил бий болдог. Тиймээс иргэд төрдөө хяналт тавих, хариуцлага тооцох иргэдийн үйл ажиллагааны үндэс нь мэдээллийн эрх чөлөө юм.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйл Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний *17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй* гэж заасан нь ардчилсан тогтолцоот улс болохын хувьд төрийн ил тод байдлыг хангах, иргэд төрийн мэдээллийг хүлээн авах эрх зүйн үндэс суурь болсон.

Ихэнх тохиолдолд мэдээлэл авах эрх, ил тод байдал нь ижил төстэй гэж үздэг. Гэсэн хэдий ч мэдээлэл авах эрх, ил тод байх нь ижил зүйл биш юм. Жишээлбэл, ихэнх тохиолдолд хөгжиж буй орнуудын засгийн газар олон нийт, сонирхогч талуудад шаардлагатай бүх мэдээллийг задруулдаггүй. Үүнийг мөн манай улсад мөрдөгдөж эхэлсэн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-д мэдээллийг нээлттэй, хязгаарлагдмал, хаалттай гэсэн гурван түвшинд авч үзэж байгаагаас харж болно.

Төрийн оролцоог ил тод, нээлттэй байлгах үндсэн арга бол өөрийн санаачилгаар олон нийтэд мэдээллийг аль болох хүртээмжтэй болгох явдал бөгөөд үүнийг төрөөс мэдээлэл түгээх идэвхтэй арга гэж нэрлэдэг. Энэ нь хамгийн хэмжих боломжтой, чиг үүргийнх нь дагуу сайжруулах боломжтой суваг юм. Мэдээллийг түгээхдээ цахим хэрэгсэл ашиглах нь мэдээллийн дотоод эх сурвалж буюу мэдээлэгчийн мэдээлэл алдагдлыг хянах боломжийг олгож байдгаараа давуу талтай. Дэлхийн банкнаас гаргасан

өгүүлэлд мэдээлээ идэвхтэй түгээх нь цахим технологи бидний өнөөгийн амьдралд хүчтэй нөлөө үзүүлж буй эрин үед иргэдийн мэдэх эрхийг хангах ирээдүй хэмээн онцлон тэмдэглэсэн. Үүнд нөлөөлөгч дөрвөн хүчин зүйлийг тэмдэглэсэн нь эрх зүйт ёс (rule of law), хариуцлагатай байдал (accountability), үйлчилгээний хүртээмж (access to services), оролцоо (participation) юм (Darbishire, 2010). Эдгээр хүчин зүйлс тухайн төрийн байгууллага болон төрийн байгууллага хоорондын мэдээллийг өргөн хүрээнд идэвхтэй түгээхэд болон мэдээлэл хүсэх, хүлээн авах эрхийн аль алиныг нь дэмждэг давуу талтай.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг ба Нийгмийн комисс: “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй, хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ (UNESCAP 2011). Иймээс ч олон судалгаа, индексүүдэд ил тод байдал нь ил тод болсон мэдээллийн хэмжээ, цар хүрээтэй холбоотой байдаг. Гэсэн хэдий ч ил тод байдлын үндсэн ойлголт нь төрийн үйл явц өөрөө ил тод байх ёстой гэсэн үзэл санаанд оршдог.

Ил тод байдал нь хамтын ажиллагаанд тулгуурладаг: төрийн албан хаагчид мэдээллийг нээлттэй болгох ёстой бөгөөд нөгөөтээгүүр мэдээллийг ашиглах шаардлагатай буюу боломжтой хүмүүс, бүлэг байх ёстой (Johnston M., 2004). Энэ үүднээс авч үзвэл мэдээллийн ил тод байдал нь эрэлт, нийлүүлэлт гэсэн талуудтай. Мэдээллийг ил тод болгох эрэлт гэдэг нь олон нийт, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл болон бусад оролцогч талуудад төрийн үйлчилгээ авах, шийдвэр гаргахад оролцох, төрийн үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай мэдээллийн цогц юм. Мэдээллийн ил тод байдлын *эрэлтийн талыг мэдээлэл авах эрх* гэж өргөнөөр ойлгодог. Нөгөөтээгүүр, мэдээллийн ил тод байдлын *нийлүүлэгч тал гэдэг нь төрийн байгууллагуудын олон*

нийтийн хэрэгцээнд зориулан гаргаж буй мэдээллийн багц юм. Үүнийг бид ил тод байдал гэж үздэг. Харин мэдээллийг ил тод болгохдоо МХХТ ашиглан цахим хэлбэрээр нээлттэй, хүртээмжтэй хүргэхийг **цахим ил тод байдал** гэж тодорхойлж болно.

Эдгээр тодорхойлолтоос үзвэл ил тод байдлыг бий болгох процесс нь мэдээллийг ил тод болгох үр дүн бус тасралтгүй үйл явц гэдэгт төвлөрч байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүн бус мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх, түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чадамж байгаа эсэх, үүний үр дүнд иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн, хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх үйл явцыг үнэлэх

юм. Тиймээс **цахим ил тод байдлыг хэмжих загвар** нь мэдээлэл авах эрхийг хангаж буй i) эрх зүйн орчин бүрдсэн эсэх, ii) мэдээлэл өгөх үүрэг бүхий төрийн байгууллагын чадавх, iii) технологийн тусламжтай хүрч буй мэдээллийн агуулга нь иргэдэд бүрэн, цаг хугацаандаа хүрч чадаж байгаа эсэхийг цогцоор нь үнэлэх оролдлого юм.

Индекс нь зөвхөн тоон утгаар хэмжигдэж, ил тод байдлын түвшнийг тодорхойлдог тул төрийн байгууллагуудын ил тод байдал яагаад буурч эсвэл нэмэгдэж байгаа талаар нарийвчилсан мэдээлэл өгөх нь уг судалгааны арга зүйн хүрээнд багтдаггүй болно.

Уг индексийн хүрээнд хэмждэг төрийн байгууллагын цахим ил тод байдлыг хэмжих гурван бүрэлдэхүүн хэсгийг дараах хэсгүүдэд танилцууллаа.

ЗУРАГ 2

Цахим ил тод байдлын индексийн хүрээ



Бодлогын орчин бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлдэг. Бодлогын орчны бүрэлдэхүүн хэсэг, түүнд харгалзах индикаторууд нь олон улсын, үндэсний, байгууллагын гэсэн гурван түвшинд үнэлэгдэхийн сацуу зарим салбарын шинжтэй үзүүлэлтүүдийг хамардаг. Олон улсын түвшинд тодорхойлсон индикаторын дагуу харгалзах индексүүдийн оноог хөрвүүлэх байдлаар ашигладаг. Түүнчлэн, тухайн улс оронд төрийн байгууллагыг мэдээллээ ил тод, нээлттэй болгох нөхцөлийг хэрхэн хангаж байгаа талаар дэлгэрэнгүй авч үздэг. Байгууллагын түвшинд эдгээр бодлого, журмыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн байгууллагадаа тохирсон дүрэм, журмыг баталж, мөрдүүлж байгаа эсэх, хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа эсэхэд анхаарах юм. Өмнөх арга зүйд энэ хэсгийн бүрэлдэхүүн нь бодлогын орчныг ерөнхийд нь үнэлж, ерөнхий нэг бүрэлдэхүүн хэсгийн индекс тооцдог байсан бол шинэчилсэн арга зүйгээр байгууллага тус бүрд мэдээллийн цахим ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг нэмж үнэлдэг болсноор байгууллага бүр ялгаатай үнэлэгдэх боломжтой болсон.

ЗУРАГ 3

Бодлогын орчныг үнэлэх түвшин



Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсэг нь тухайн төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлыг хангах чадавхад чиглэгдэнэ. Өмнөх жилүүдэд манай байгууллагаас хийж ирсэн 'Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын мониторинг' нь мэдээллийн ил тод байдлыг хангах явдал нь тухайн байгууллагын чадавх, нөөцөөс ихээхэн хамаардаг болохыг харуулсан. Үүнд мөн мэдээллийг ил тод болгох дүрэм, журам, түүнийг хангуулах удирдлагын манлайлал ч чухал үүрэгтэй. Ихэнх тохиолдолд цахим ил тод байдлыг хангах процесс болон дүрэм, журам тодорхой байдаггүйгээс мэдээлэл хангалттай хэмжээнд ил тод болж чадахгүй байна. Тиймээс үүнийг бид бүхэн хэмжих оролдлогыг эхний бүрэлдэхүүн хэсэгт байгууллагын эрх зүйн орчны хэсэгт нэмж авч үзэх шаардлагатай болсон.

Төрийн байгууллагын цахим ил тод байдлыг хангах чадамж нь дотоод дүрэм журмын тодорхой байдлаас гадна мэдээллийг ил тод болгох үйл явцын тодорхой байдал болон хүний нөөцийн чадавх, технологи ашиглах чадамж, технологи нь мэдээллийг ил тод болгоход хэр нийцтэй ажиллаж байгаа вэ гэдгээр тодорхойлогдоно.

2019 онд боловсруулагдсан эхний арга зүйгээр энэ хэсгийн үнэлгээг зөвхөн тухайн байгууллагын албан хаагчийн анхдагч мэдээлэлд тулгуурлан үнэлдэг байсан. Шинэчилсэн арга зүйгээр оролцогчийн субъектив нөлөөллийг аль болох багасгаж, цахим хуудасны технологийн үзүүлэлтүүдийг илүү авч үзэх болсноороо онцлог юм. Учир нь аливаа цахим хуудасны үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын технологийн чадамжийг харуулах нэг үндсэн үзүүлэлт мөн гэж үзсэн. Түүнчлэн байгууллагын мэдээллийг ил тод болгох үйл явц болон хүний нөөцийн чадавхыг үнэлэхдээ анхдагч болон хоёрдогч мэдээллийг хослуулсан хэлбэрээр авч үзэх болсон.

Цахим нээлттэй мэдээлэл бүрэлдэхүүн хэсэг нь илүү олон нийтийн мэдээлэл авах эрх хангагдаж байгаа эсэхэд (гарц) төвлөрөх ба 'Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль'-д заасан 'нээлттэй'-ээр байршуулахаар заасан мэдээллийн агуулгад төвлөрөх ба тус хуулийн:

- 8.8-д ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ **цахим хуудас**, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл **ашиглана**.
- 8.12.Мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран мэдээлэл хариуцагч **цахим хуудас**, мэдээллийн самбарыг **заавал ажиллуулах ба цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангана**.
- 8.13.Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах тохиолдолд тус мэдээллийг өгөх эх сурвалжийг цахим хуудсанд тодорхой заасан байна зэрэг заалтуудад үндэслэн үр дүнг тооцно.

Ингэхдээ зөвхөн холбогдох хууль, журамд заасан мэдээлэл байгаа эсэхийг хэмжих бус цаг хугацааны нийцтэй байдал буюу заасан цаг хугацаандаа нийтэлсэн эсэхийг давхар хянасан. Мэдээллийн цар хүрээг хэмжихээс гадна мэдээлэл авах эрхийг хангах, эрэлтийг бий болгоход чиглэсэн үйл явц буюу эгэх холбоо байгаа эсэх нь энэ бүрэлдэхүүн хэсгийн бас нэгэн гол үзүүлэлт юм. Үүнийг бид индексийн нэг чухал хэсэг болгон авч үзсэнээр цаашид иргэд, олон нийттэй харилцах, мэдээллийг шуурхай түгээхэд онцгой ач холбогдолтой гэж үзэж байна.

1.3. Индексийн бүтэц ба хэмжих аргачлал

Ихэнх индексийн адилаар индикаторуудыг нэгтгэж, цахим ил тод байдлыг илтгэх нэгдсэн нэг оноогоор хэмжинэ. Индекс нь үндэсний болон байгууллагын түвшинд илэрхийлэгдэх боломжтой.

Индекс нь 3 гол бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 10 дэд бүрэлдэхүүн, 35 шалгуур үзүүлэлт, түүнийг тодорхойлох 150 асуулт/үзүүлэлтээс бүрдэнэ. Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу.

Цахим ил тод байдлын индексийг тооцохдоо өмнө нь эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэгт ижил жин хуваарилдаг байсан бол энэ удаа (i) бүрэлдэхүүн тус бүрийн индикаторыг хэмжих асуултын тоо болон (ii) ач холбогдлын зэргээс шалтгаалан ялгаатай жингээр тооцох арга зүйг ашигласан.

i. Цахим ил тод байдлын индексийн нийт 150 асуулт, Бодлогын орчны бүрэлдэхүүн 57, Байгууллагын чадамж бүрэлдэхүүн 29, Цахим нээлттэй мэдээлэл 48 асуулттай байна. Ингэснээр эдгээр дэд бүлгүүд тус бүр 0.13 (6/45), 0.8 (36/45) болон 0.07 (3/45) гэж жинлэгдэж байна. Жишээлбэл, эхний хүчин зүйлд Бодлогын орчны бүрэлдэхүүн хэсэг нийт үзүүлэлтийн хувьд 57 асуултаас бүрдэж байгаа учир 38% (57/150) жинтэй байна.

ii. Харин дараагийн хүчин зүйлд, бүрэлдэхүүн тус бүрийн ач холбогдлыг тэнцүү гэж үзэж байгаа тул 33.3% (1/3) байна.

Хэрвээ индикатор доторх асуултын тоо өөрчлөгдвөл эхний хүчин зүйлийн жинг дээрх аргаар хувааж тооцоолно. Тооцоолсон томьёог харуулбал:

$$DTI = \frac{1}{l} \sum_{k=1}^k \left(\frac{1}{3} \sum_{n=25} A_n + \frac{1}{3} \sum_{n=5} B_n + \frac{1}{3} \sum_{n=5} C_n \right)$$

k-Үндсэн нэмэгч индекс
l-Байгууллагын тоо
n-Индикаторын тоо

A- Эрх зүйн орчин
B- Байгууллагын чадамж
C- Цахим нээлттэй байдал

ХҮСНЭГТ 1

Хэмжих индикаторууд болон харгалзах оноо

Код	Индикаторууд	Дээд оноо
Е. Бодлогын орчин		57
E1	Мэдээлэл авах эрх (Олон улс)	8
E2	Засаглал (Олон улс)	12
E3	Иргэний нийгэм (Олон улс)	15
E4	Улсын түвшний бодлого, зохицуулалт	14
E5	Байгууллагын түвшний зохицуулалт	8
О. Байгууллагын чадамж		29
O1	Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц	12
O2	Цахим хуудасны технологийн нийцтэй байдал	11
O3	МХТ-ийн чадавх	6
D. Цахим нээлттэй мэдээлэл		48
D1	Нээлттэй мэдээлэл	39
D2	Харилцаа холбоо ба эгэх холбоо	9
Нийт		150

Индексийн үр дүн нь 0-100-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 100 руу дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сайн, харин буурах тусам хангалтгүй байгааг харуулна. Цахим ил тод байдлын индексийн үр дүнгийн утгыг доорх зурагт нэгтгэн харууллаа.

ЗУРАГ 4

Индексийн үр дүнгийн утгын ангилал

Сайн	≥0.80	Цахим ил тод байдлыг бий болгох, мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
Хангалттай	0.65-0.79	Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
Сул	0.50-0.64	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой зарим үзүүлэлт байгаа. Цаашид байгаа мэдээллүүдийг шинэчлэх, тогтвортой хангах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.
Хангалтгүй	0.35-0.49	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар суурь түвшний процедур, нөөц, хариуцлагатай, ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
Муу	<0.35	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй, энэ нь эргээд цахим хуудсаар мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

2. Үр дүн

2.1. Нэгдсэн үр дүн

Төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 93 байгууллагын 2022 оны цахим ил тод байдлын ерөнхий индекс 63.1%, төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд байна. Уг үр дүнг 2021 онтой харьцуулахад (60.2%) бага зэрэг өссөн байгаа ч ангиллын хувьд ялгаагүй 'сул' түвшинд хэвээр байна. Нийт хамрагдсан төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшнийг ангилан харвал 36.6% нь 'хангалттай' түвшинд бусад нь сул, хангалтгүй түвшинд үнэлэгдлээ. Харин 'сайн' буюу 80%-аас дээш түвшинд цахим ил тод байдлаа хангасан байгууллага байгаагүй.


Үүнийг өмнөх онтой харьцуулбал 'сул' түвшинд байгаа байгууллагын эзлэх хувьд өөрчлөлт гараагүй. Харин 'хангалтгүй' үзүүлэлт 8%-аар буурч, 'хангалттай' түвшин 8%-аар өссөн нь эерэг үзүүлэлт юм.

2.1.1. Цахим ил тод байдлын өөрчлөлт

IRIM судалгааны хүрээлэн нь 2010 оноос төрийн байгууллагын цахим ил тод байдлыг хэмжиж эхэлсэн ба 2014 оноос хойш тасралтгүй уг үнэлгээг хийсээр байна. 2018 он хүртэл зөвхөн цахим хуудсанд үнэлгээ хийж, ил тод байдлыг "Хаалттай", "Зарим талаар ил тод", "Ил тод", "Бүрэн ил тод" гэсэн 4 түвшнээр үнэлж байсан бол 2019 оноос эхлэн 'Цахим ил тод байдлын индекс' болгон шинээр хоёр үндсэн бүрэлдэхүүн нэмж, тус бүрд өөр өөр эх сурвалжаас мэдээлэл авдаг болж, одоогийн 5 түвшнээр үнэлдэг болсон. Арга зүйд тогтмол шинэчлэл хийгдэж ирсэн ч эдгээр оны үр дүнг хооронд нь харьцуулах боломжтой ба доорх дүрсэд нэгтгэсэн үр дүнг харуулж байна.


ЗУРАГ 5

Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь



ЗУРАГ 6

Цахим ил тод байдлын өөрчлөлт, оноор



Мониторинг хийснээс хойш 11 жилийн хугацаанд төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн агуулга, хүртээмж бага багаар сайжирсан боловч зарим жилүүдэд доогуур үнэлэгдэж ирсэн. Үүнийг он цагаар нь тодруулан харвал сонгууль болж, Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орох нь төрийн байгууллагын цахим ил тод байдалд нөлөө үзүүлж байгаа нь ажиглагдсан.

2.2. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн

Өмнөх хэсэгт дурдсанчлан шинэ нөхцөл байдлуудтай холбоотойгоор арга зүйд шинэчлэлүүд хийж, зарим индикаторууд өөрчлөгдсөн. Тиймээс дэд бүрэлдэхүүн болон индикатор тус бүрийг өмнөх онтой харьцуулах боломж хязгаарлагдмал хэдий ч бүрэлдэхүүн тус бүрийн гол агуулга, зорилго өөрчлөгдөөгүй тул ерөнхий үр дүнг харьцуулах боломжтой.

ЗУРАГ 7

Цахим ил тод байдлын нэгдсэн үр дүн, бүрэлдэхүүн тус бүрээр



¹ Бүрэлдэхүүн тус бүрийн индекс дэд бүрэлдэхүүний нийлбэрээр тодорхойлогдоно.

2.2.1. Мэдээллийг ил тод болгох бодлогын орчны нөхцөл байдал

Мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлэхэд бодлогын орчны дэмжлэг, тогтолцоо суурь шинжтэй буюу тэргүүлэх ач холбогдолтой. Тиймээс эхлээд мэдээллийн цахим ил тод байдлыг хангахад бодлогын орчныг хэр бүрдүүлсэн бэ гэдгийг анхаарах нь зүйтэй. Бодлого, зохицуулалтын орчны ил тод байдлыг ханган ажиллах боломж нөхцөлийг хэр хангасныг олон улс, үндэсний болон байгууллагын түвшинд нарийвчлан үнэлсэн. Энэ бүрэлдэхүүн хэсгийн үр дүнг өмнөх жилүүдэд олон улсын түвшинд гарч буй засаглалын ил тод байдлын үзүүлэлтүүд болон үндэсний түвшний бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ өгдөг байсан бол 2022 оноос байгууллагын түвшинд цахим ил тод байдлыг хангах чиглэлээр батлан хэрэгжүүлж буй бодлого, журам байгаа эсэхийг нэмж үнэлэх болсон төдийгүй олон улс, үндэсний түвшний хэмжих шалгуур үзүүлэлт бүхий эх сурвалжуудыг өргөтгөснөөрөө онцлог юм.

Бодлогын орчин 'хангалттай' (78.8%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2021 оны үр дүнтэй харьцуулахад (63.1%) 'сул' гэсэн ангиллаас 15.7% өссөн үзүүлэлт юм. Үүнийг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна².

Олон улсын түвшний үзүүлэлтүүдийг холбогдох чиглэлд олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн, Монгол Улс хамрагдсан индексүүдэд үндэслэн 2019 онд гаргасан Мэдээлэл авах эрх, Засаглал, Иргэний нийгэм гэсэн гурван дэд бүрэлдэхүүнээр хамрах ойлголтын хүрээг авч үзсэн. Өмнө нь 5 олон улсын индексээс энэ бүрэлдэхүүн хэсгийн үр дүн тооцоологдоог байсан бол шинэчилсэн аргагүйгээр 11 индекс болж эх сурвалж, хэмжих олон талт байдал сайжирсан. Эдгээрийн үр дүнд цахим ил тод байдлыг үнэлж буй олон улсын индексүүд Монгол Улсыг бидний үнэлгээний аргачлал дагуу 'хангалттай' түвшинд үнэлж байна. Ашгийн Төлөө Бус Хуулийн Олон Улсын Төв (ICN-L)-өөс гаргасан эрх зүйн шинжилгээнээс бусад индексүүдэд 2022 онд шинэчлэн батлагдан гарсан "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-н орчинтой холбоотой үнэлгээ хийгдээгүй байв. Өмнөх хуулийн хүрээний эрх зүйн орчин дахь нөхцөл байдал нь мэдээлэл авах суурь эрхийг хангахтай холбоотой хуультай бөгөөд үүгээрээ дамжуулан мэдээлэл олж авах харилцаа ерөнхийдөө хангалттай зохицуулагдсан, засаглалын хувьд мэдээллийг ил тод болгох механизм тал бүрээр тодорхой хэмжээнд хангагдсан, иргэд, олон нийтийн оролцоог хангахтай холбоотойгоор ерөнхий байдлаар энэ төрлийн орчныг бүрдүүлэх тогтолцоо тодорхой хэмжээнд байгаа гэсэн үр дүн гарч байна. Олон улсын индексүүдээр бүх үзүүлэлтүүдийн дунджаар Монгол Улс 171 орноос 62-р байранд эрэмбэлэгдэж байна. Ашигласан эх сурвалжийн хураангуйг Хүснэгт 2-т харуулав.

ЗУРАГ 8

Бодлогын орчны индекс



² Бодлогын орчны бүрэлдэхүүний оноо дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

ХҮСНЭГТ 2

Бодлогын орчны хүрээнд хамруулсан олон улсын индексүүд

Индексүүд	Гаргасан байгууллага	Гарсан он	Монгол Улсын эрэмбэ	Хамрагдсан улсын тоо
Right to Information (RTI) Rating	Centre for Law and Democracy	2018	64	135
Rule of Law Index	World Justice Project	2022	62	139
World Governance Indicators (WGI)	World Bank	2022	46	214
Bertelsmann Transformation Index (BTI)	Bertelsmann Stiftung	2022	26	137
Freedom House Index	Freedom House	2022	55	210
Global Civic Engagement	Gallup	2016	25	140
World Press Freedom Index	Reporters without borders	2022	90	180
Varieties of Democracy (V-Dem)	V-Dem Institute	2022	121	179
Global Indicators of Regulatory Governance	World Bank	2018	56	185
E-Government Development Index	United Nations	2022	74	193
Civic Freedom Monitor	International Center for Not-for-profit Law (ICNL)	2022		
Дундаж		2020	61.9	171.2

Үндэсний түвшний дэд бүрэлдэхүүнд Монгол Улсын урт болон дунд хугацаанд баримтлах хөгжлийн баримт бичиг, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой батлагдсан шинэ хууль болон түүнийг даган гарах журмуудыг хамруулан авч үзсэн. Үр дүнд нь эдгээр баримт бичгүүдэд мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой агуулга ‘хангалттай’ орсон боловч зохицуулалтын орчин тодорхойгүй байна. Тэр дундаа мэдээллийг ил тод болгож буй үйл ажиллагаанд хяналт тавих, сайжруулах механизм дутагдалтай байна. Дэлгэрүүлбэл, урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тус бүрдээ энэ төрлийн агуулгыг зорилтот хэлбэрээр тодорхойлж, хоорондын уялдаа сайтар хангагдсан. Шинээр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар тодорхой түвшинд мэдээллийн ил тод байдлыг сайжруулах алхмууд хийгдсэн боловч энэ чиглэлийн зарчмуудыг хангах, хуулийн зохицуулалт бүрэн тодорхой байх үзүүлэлтүүдийн хүрээнд сайжруулах орон зай цаашид тулгарч байна. Харин уг хуулийг даган гарахаар тодорхойлогдсон 12 журмын хүрээнд хэмжих үзүүлэлтүүд хяналт тавих механизмаас бусад нь маш сайн хангагдсан байна.

Байгууллагын түвшний дэд бүрэлдэхүүнд анх удаа мэдээллийн ил тод байдлыг хангах байгууллагын дотоод зохицуулалттай холбоотой 8 үзүүлэлт гарган уг мониторингд хамрагдаж буй байгууллага тус бүр дээр үнэлсэн. Үр дүнд нь нийт 93 байгууллагын 61.3% нь мэдээлэл авах эрхийг хангах хууль, түүнийг даган гарсан журмуудын хүрээнд байгууллага дотооддоо зохицуулалтаа хангах баримт бичиггүй буюу албан ёсны цахим хуудастаа байршуулаагүй байна. Байгууллагын түвшинд дунд хугацааны бодлогын баримт бичгүүддээ цахим мэдээлэл болон мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой заалт бараг бүгдэд нь туссан боловч маш ерөнхий байдлаар тусгажээ. Зарим бодлогын баримт бичгийн агуулгад цахим мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой тусдаа журам гаргаж хэрэгжүүлэхээр заасан боловч одоогоор тусдаа тушаал, журам баталсан байгууллага маш цөөн буюу 22.6% нь тусдаа баримт бичгийг батлан мөрдөж байна. Хэдийгээр зарим байгууллагууд цахим ил тод байдлыг хангах чиглэлээр дотооддоо журам, тушаал гарган мөрддөг ч цаг хугацааны хувьд хуучирсан буюу цаг үеийн байдлаа алдсан, эсвэл үйлчлэх хүрээний хувьд хязгаарлагдмал

байна. Тодруулбал, 2022 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн шинээр гаргасан тушаал, журам батлан хэрэгжүүлж буй байгууллага харахан алга байв. Мөн батлагдсан журмуудад тусгасан ил тод байдлыг хангахтай холбоотой мэдээлэл ихэнх тохиолдолд Шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг хугацаанд нь ил болгох тухай агуулгыг тусгасан бусад мэдээлүүдэд төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа байдал ажиглагдлаа. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-н зохицуулалттай холбоотойгоор дотоод журмаа сүүлийн жилүүдэд шинэчилсэн, хууль, журмуудад дурдсан агуулгууд бүрэн орж тусгагдсан болоод мэдээллийн ил тод байдлыг хангах дотоод үйл явцын тогтвортой байдлыг хангах үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлэхэд 4.3% нь л эдгээр агуулгуудыг хангалттай түвшинд тусгасан байна. Энэ ердөө 4 байгууллага бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Үндэсний статистикийн хороо, Гадаад харилцааны яам, Архивын ерөнхий газрын журмууд байв.

Тиймээс мэдээллийн цахим ил тод байдлыг хангах талаар дотооддоо журам, тушаал гарган хэрэгжүүлэх, үүнд мэдээллийн цар хүрээг тодорхойлох, мэдээллийг бэлтгэгч, нийтлэгчдийн эрх, үүргийг тусгах, мэдээллийг шинэчлэх хугацаа, хяналт зэргийг тодорхой тусгах нь үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.2. Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох чадамж, бэлэн байдал

Ил тод байдлыг хангахын тулд мэдээллийг нийлүүлэгч буюу тухайн байгууллагын мэдээллийн тасралтгүй үйл явцыг хангах чадамж, бэлэн байдал нь чухал үүрэгтэй. Тиймээс энэ бүрэлдэхүүн хэсэгт мэдээллийг ил тод болгох хүний нөөцийн чадавх, бэлэн байдал, МХХТ-ийг ашиглах чадавх болон цахим хуудасны стандарт шаардлагуудад нийцсэн эсэхэд анхаарал хандуулсан. Өмнөх арга зүйгээс ялгаатай нь (i) энэ бүрэлдэхүүн хэсгийн мэдээллийн эх сурвалж бүхлээрээ тухайн байгууллагын холбогдох ажилтнаас авдаг анхдагч мэдээлэлд үндэслэдэг байсан нь субъектив шинжтэй, мэдээлэл авч чадаагүй тохиолдолд энэ хэсгийн индексийг бүхлээр нь тооцох боломжгүй болдог байсан сул талыг багасгахыг зорьсон, (ii) цахим хуудасны стандарт болон техник шаардлагыг өмнө нь нээлттэй мэдээллийн агуулга бүрэлдэхүүн хэсэгт хамааруулж авч үздэг байсан бол үүнийг байгууллагын чадавхыг харуулах нэг үндсэн үзүүлэлт гэж үзэн цахим хуудасны технологийн нийцтэй байдал гэсэн дэд бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэж байна.

Байгууллагын чадамж ‘хангалттай’ (66.2%) түвшинд үнэлэгдсэн. Гэвч буцаад ‘сул’ түвшинд орох эрсдэл өндөр байна. Энэ үр дүнг 2021 онтой харьцуулахад (62.7%) ‘сул’ гэсэн ангиллаас өссөн байна. Үүнийг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна³.

ЗУРАГ 9

Байгууллагын чадамжийн индекс



³ Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүний оноо дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Нийт мониторингд хамрагдсан төрийн байгууллагуудын 61.3% нь мэдээлэл ил тод болгох үүрэг бүхий хариуцсан ажилтан болон алба, нэгжтэй, 26.9% нь энэ үүргийг хавсран гүйцэтгэдэг, 11.8% нь мэдээллийг ил тод болгох үүрэгтэй ажилтан байхгүй эсвэл байгаа эсэх нь тодорхойгүй байна. Мэдээллийг ил тод болгохтой холбоотой төсөв, хөрөнгө төрийн байгууллагуудын тал хувьд нь тодорхой хэмжээнд суулгадаг боловч энэ нь хүрэлцээгүй байдаг нь ажиглагдаж байна.

Ихэнх төрийн байгууллагууд цахим ил тод байдлыг бий болгох дотоод төлөвлөгөө, стратеги байдаггүй нь өмнөх бүрэлдэхүүн хэсгийн үр дүнгээр илэрхий болсон. Тиймээс олон нийтэд түгээх мэдээллийн цар хүрээг тодорхойлж, байгууллагын ажилтнуудад танилцуулах байдал сул байна. Мөн мэдээллийг ил тод болгох үйл явц хангалтгүй, холбогдох мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, сургах байдал хязгаарлагдмал байна. Хэдийгээр зарим байгууллагууд ил тод байдлыг хангах төлөвлөгөөг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг боловч түүнийг хянах, үр дүнг үнэлэх ажил сул байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал, зарим тохиолдолд өөрсдийн сошиал хуудсаар нийтэлсэн тайлан, мэдээллийг биелэлтийн тайлангууддаа тусгадаг хэр нь цахим хуудсандаа анализ хийдэггүй тохиолдол байна.

Бусад холбогдох байгууллагуудын болон төрийн нэгдсэн мэдээлэл, үйлчилгээнүүдийн (e-Mongolia, 11-11, legalinfo) холбоосыг цахим хуудас дээрээ байршуулах, холбож өгөх байдал жигд сайн байна. Мөн өөрсдийн сошиал хаягуудыг ч байршуулсан байна. Гэвч зарим байгууллагууд өөрсдийн үзүүлдэг үйлчилгээ болон мэдээллийн тусдаа цахим хуудсыг ажиллуулж байгаа боловч энэ тэдгээрийг үндсэн цахим хуудастайгаа холбоогүй нь мэдээллийг хэрэглэгчдэд хүртээмжгүй болгоход нөлөөлж байна.

Цахим хуудасны технологийн нийцтэй байдлын хувьд цахим хуудасны өнгө, дизайн, цэсийн бүтцийн хувьд жил ирэх тусам сайжирч, хөгжүүлж байгаа боловч дотор нь байршуулж буй мэдээллийг ашиглахад хялбар байлгах тал

дээр сайжруулах шаардлага байсаар байна. Тухайлбал, хүссэн мэдээллээ цахим хуудаснаас хайх хэсэг байхгүй цахим хуудас олон байгаа ба ялангуяа агентлагуудын цахим хуудаст энэ байдал нийтлэг байгааг дурдах нь зүйтэй.

Байгууллагууд цахим хуудсандаа үйл ажиллагаатайгаа холбогдох баримт бичгүүдийг байршуулах тусдаа цэс үүсгэсэн байдал сайн байна. Гэвч байршуулсан файлуудын нэрийг нь бүрэн оруулаагүй ерөнхий оруулснаар иргэд өөрт хэрэгтэй хүчин төгөлдөр мөрдөгдөж буй баримт бичиг, тушаал, шийдвэрийг олж ашиглахад хүндрэлтэй байдлыг үүсгэжээ. Файлуудыг татаж авах боломжууд нэмэгдэж байгаа ч бусадтай хуваалцах, илгээх боломж бага байгааг цаашид анхаарах хэрэгтэй. Тухайлбал,

- Хүчин төгөлдөр биш баримт бичгүүдийг устгаагүй хэвээр байгаа нь иргэдийг төөрөгдүүлэх эрсдэлтэй. Жишээ нь, Нийтийн мэдээллийн тухай хууль батлагдаад, хэрэгжиж байгаа боловч холбогдох баримт бичгийн жагсаалтад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг байршуулсан хэвээр байна.
- Мөн тухайн байгууллагын удирдлагаас баталсан тушаал, шийдвэрийн актыг нийтэлсэн боловч хавсралт болох гол агуулга бүхий баримт бичгийг нь оруулаагүй байдал хэд хэд тохиолдсон.
- Мөн тушаал, шийдвэрийн нэршил бүрэн биш, PDF форматаар файлыг оновчтой нэрлээгүй хавсаргасан зэрэг нь иргэд өөрт хэрэгцээт мэдээллээ шууд олж авах боломжийг хязгаарлаж байна. Жишээлбэл, эхний зурагт захирамжийн агуулгыг шууд хараад мэдэх боломжгүй учир заавал нээж үзэх шаардлага үүсэж, үүнд хэрэгцээт мэдээллийг хайхад их цаг зарцуулахаар байгаа бол хоёр дахь зурагт үзүүлснээр шууд гарчгийн агуулгаас хэрэгцээт мэдээллээ авах болон файлыг шууд татах боломжтой байна. Мөн иргэд мэдээллийг шууд үзэх боломжтой жишээг дараах холбоосоор харна уу. [Захирамж Archives - Багануур \(ub.gov.mn\)](http://ub.gov.mn/Archives)

ЗУРАГ 10

Баримт бичгийг ойлгомжтойгоор хүртээмжтэй байршуулсан жишээ

Буралдагч	#	Гарчиг	Дугаар	Огноо	Хавсралт
ТАЗ-с гаргасан зөвлөмж, шийдвэр		Хайлтын утга	Хайлт	Хайлтын ут	Хайх
Тогтоол шийдвэр	21	Дэлгэрээн сумын Засаг даргыг Тамгын газрын Байрлах орныг асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	59	2022.06.09	Yasakh / Tatak
Сул орон тоо	22	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн эсрэггүй байдал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	48	2022.06.09	Yasakh / Tatak
Иргэний нөөцийн жагсаалт	23	Жиргалтаан сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	39	2022.06.09	Yasakh / Tatak
Сонгон шалгаруулалт	24	Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	66	2022.06.09	Yasakh / Tatak
Тайлан мэдээ	25	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	57	2022.06.09	Yasakh / Tatak
	26	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Гурванбаны тосгоны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	46	2022.06.09	Yasakh / Tatak
	27	Батцорос сумын Сайнхан төвийн даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	74	2022.06.09	Yasakh / Tatak
	28	Баян-Аадарга сумын Засаг даргын Тамгын газрын даргын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	37	2022.06.09	Yasakh / Tatak
	29	Жиргалтаан сумын Засаг даргыг Тамгын газрын Хүнс ажлаа дэмж, үйлдвэр, харилцаа асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	64	2022.06.09	Yasakh / Tatak
	30	Аймгийн Татварын хэлтсийн Татварын улсын байцагчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	53	2022.06.09	Yasakh / Tatak
	31	Аймгийн Мэргэжлийн хэлтсийн Газрын Хүний нөөцийн эрх зүйн асуудал хариуцсан албан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай	55	2022.06.09	Yasakh / Tatak

Төрийн байгууллагуудын МХХТ-ийн чадавх бүхий мэргэжилтнүүд төрийн байгууллагын ихэнхэд нь байдаг ба мэдээллийн аюулгүй байдлаа тодорхой хэмжээнд хангах чадавх болон зохицуулалт байгаа нь сайшаалтай. Хэдийгээр мэдээллийн агуулга, хүрээг байгууллагын хэмжээнд тодорхойлсон тодорхой баримт бичиг байхгүй байгаа боловч тогтмол шинэчлэгдэж байдаг мэдээллийн сан ихэнх байгууллагад бий болж, тогтмолжсон байгаа нь харагдлаа. Тиймээс ихэнх төрийн байгууллага хуулийн хүрээний мэдээлэл болон цаг үеийн мэдээллийг шинэчлэн оруулдаг, шинэчлэлүүдийг нь харах боломж бүрдсэн байна.

2.2.3. Цахим мэдээллийн нээлттэй байдал

Уг бүрэлдэхүүн хэсэгт төрийн байгууллагуудын цахим хуудсаар ил болгож буй нээлттэй мэдээллүүд нь хуульд тогтоосон хугацааны дагуу цахим хуудаст байршиж байгаа эсэхийг тодруулсан. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга

ЗУРАГ 11

Баримт бичгийг ойлгомжгүй, хүртээмжгүй байршуулсан жишээ

The figure shows four examples of government portals with poor accessibility. Each example features a large '2023' graphic and a search bar. The first two examples show search results for 'Засаг даргын захирамж /2023 он А/88 - А/113/' and 'Засаг даргын захирамж /2023 он А/72 - А/87/'. The last two examples show search results for 'Засаг даргын захирамж /2023 он А/88 - А/113/' and 'Засаг даргын захирамж /2023 он А/72 - А/87/'. The portals lack proper alt text and keyboard navigation, making them difficult to use for visually impaired users.


нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 'нээлттэй мэдээлэл'-ийг хамрах ба хуульд хэр нийцэж байгаад төвлөрсөн. Мөн Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад дүрэм журамтай уялдсан байх шаардлагатай.

Цахим мэдээллийн нээлттэй байдал 'хангалтгүй' (45.6%) түвшинд үнэлэгдсэн. Уг үр дүнг 2021 онтой харьцуулахад (62.7%) 'сул' ангиллаас буурсан байна. Энэ нь мэдээллийн ил тод байдлын эрх зүйн шинэчлэлтэй шууд холбоотой. Өмнө дурдсанчлан энэ удаагийн мониторинг нь Нийтийн мэдээллийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шинэ хуулийн дагуу мэдээллийг байгууллагууд байршуулж хэвшээгүй байна. Тиймээс энэ нь шинэ хуулийн мониторингийн суурь үзүүлэлт болж байгаагаараа онцлог гэдгийг дахин дурдах нь зүйтэй. Үүнийг дэд бүрэлдэхүүн тус бүрээр задлан харвал дараах үр дүн харагдаж байна⁴.

⁴ Цахим мэдээллийн нээлттэй байдлын бүрэлдэхүүний оноо дэд бүрэлдэхүүн тус бүрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

ЗУРАГ 12

Цахим мэдээллийн нээлттэй байдлын индекс



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 'нээлттэй' байхаар заасан төрийн байгууллага бүрд хамааралтай ерөнхий мэдээллийгагуулгаарнь харвал байгууллагатай холбоо барих хаяг, утас, байршлын мэдээлэл 1-2 байгууллагаас бусад нь бүгд ил тод байна. Харин тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг олонх байгууллагууд байршуулаагүй байна. Нийтийн мэдээллийн тухай хуульд заасан дараах тайлан мэдээллүүдийг төрийн байгууллагууд бүгд жигд ил тод байршуулжээ. Үүнд:

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт
- Статистик мэдээлэл
- Судалгаа, шинжилгээний тайлан
- Үйл ажиллагааны тайлан
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан
- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэр, бусад акт

Мөн хүний нөөцийн ил тод байдлыг хангах мэдээллүүдийг төрийн байгууллагууд маш сайн байршуулсан байна. Ялангуяа, хэлтсийн дарга нарын нэр, холбогдох утас, өрөөний дугаар зэргийг бүх байгууллага ил тод байршуулах байдал жигд сайн байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад илт дээшилсэн үзүүлэлт ба хэрэглэгчдэд ойртсон сайн үр дүн юм. Үүнээс гадна сул орон тооны зар, албан хаагчтай холбоотой дүрэм, журмууд, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх болон хүний нөөцийн удирдлагыг ил тод болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаарх

мэдээллийг ч ихэнх байгууллага байршуулжээ. Төсвийн ил тод байдлын талаарх мэдээллийг төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийг бүтэн жилээр байршуулсан байдал сайн байгаа боловч улирал, хагас жилээр байршуулж, цаг тухай бүрд нь шинэчлэх байдал бага зэрэг сул байна. Мөн нийт байгууллагуудын тал хувь (55.6%) нь 2021 оны санхүүгийн аудитын дүгнэлтийг байршуулаагүй ба аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллээ 42.9% нь байршуулжээ. Тиймээс аудиттай холбоотой мэдээллүүдийг ил тод байршуулах асуудлыг сайжруулах шаардлагатай нь харагдаж байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хуульд заасан үзүүлэлтүүдээр хэмжихэд ихэнх байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн урилга, баримт бичиг зэрэг мэдээллүүдээ ил тод нээлттэй байршуулсан байна. Харин 60 гаруй хувь нь тендер шалгаруулалтын үр дүн болон шалтгаан зэргийг байршуулаагүй байгаа нь эдгээр үзүүлэлтийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн, 5 сая ба түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болон худалдан авах ажиллагааны аудит, бусад шалгалтын тайлан, дүгнэлтийг ихэнх байгууллага байршуулаагүй хэвээр байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн агуулгаар мэдээллээ хамгийн ил тод байршуулсан байгууллага нь (i) Барилга, хот байгуулалтын яам, (ii) Байгаль орчин, аялал жуулчлалын яам, (iii) Цахим хөгжил, харилцаа холбооны яам байна. Байгууллага тус бүрээр

ерөнхийд нь дүгнэвэл яамд мэдээллээ ил тод байршуулах байдал бусад байгууллагатай харьцуулахад сайн байна.

Хэрэглэгчидтэй харилцах ба эргэх холбоотой ажиллах нь тэдний мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Төрийн байгууллагууд хаяг, холбоо барих утасны мэдээлэл болон холбогдох албан тушаалтны нэр, холбоо барих мэдээллийг нээлттэй ил тод байршуулах байдал маш сайн байгаа боловч бодит байдал дээр утсаа авдаггүй, хариу өгдөггүй байдал нийтлэг байна. Тиймээс хэрэглэгчид төрийн байгууллагад санал, хүсэлт, өргөдөл гомдол өгөх зорилгоор шууд харилцах боломжийг нэмэгдүүлэх нь аль аль талдаа үр дүнтэй ажиллагаа юм. Харилцах сувгууд нь нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос (62.2%), e-Mongolia, 11-11 төв зэрэг үйлчилгээний линк рүү холбогдох (57.8%) боломжууд ихэнх байгууллагад бий боловч тухайн байгууллагатай шууд харилцах боломжтой цэс, тохиргоо 71.1%-д нь алга байна. Мөн 18.7% нь л иргэдтэй уулзах цагийн хуваариа ил тод байршуулжээ.


Иргэдтэй шууд харилцах боломжтой байгууллагуудын хувьд Эрүүл мэндийн

яам, Өмнөговь аймгийн ЗДТГ, Санхүүгийн зохицуулах хороод хамгийн сайн үзүүлэлттэйгээр үнэлэгдсэн байна. Эрүүл мэндийн яамны хувьд COVID-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор иргэдтэй харилцах суваг сайжирсан байх магадлал өндөр. Харин Өмнөговь аймгийн хувьд Өмнөговь өргөдөл гомдол, санал хүсэлтийн цахим систем (omnogovi.gov.mn) тусдаа цэс ажиллуулж, шууд өргөдөл гомдол гаргах, түүнийхээ хариуг цахим кодоор авах үйлчилгээг нэвтрүүлжээ. Санхүүгийн зохицуулах хороо нь мөн өргөдөл гомдол гаргах цонхонд мэдээллээ оруулан шууд илгээх боломжтой зэргийг онцолж байна.

Нийт байгууллагын 84.4% нь өргөдөл, гомдлын мэдээгээ нийтлээгүй байна. Мөн бүх байгууллагууд ямар нэг хэмжээгээр гол сонирхож буй асуудлын талаар санал, асуулга авдаг боловч түүний үр дүнг хэрхэн ашигласан талаар тодорхой мэдээлэлгүй байна.

ЗУРАГ 13

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын иргэдтэй харилцах цахим хуудас



ЗУРАГ 14

Санхүүгийн зохицуулах хорооны иргэдээс өргөдөл, гомдол авах хэсэг

2.3. Байгууллагуудын үр дүн

Энэ хэсэгт индексийн үр дүнг байгууллагын түвшинд авч үзнэ. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээнд дараах 6 төрлийн байгууллагыг жил бүр хамруулж үр дүнг гаргаж ирсэн. 2022 онд 93 байгууллагыг мониторингийн үр дүнд хамруулсан боловч энэ бүрэлдэхүүн хэсгийн тухайд 3 байгууллагын цахим хуудас ажиллахгүй (Архангай, Мал эмнэлгийн ерөнхий газар, Багахангай дүүрэг) байсан. Нийт байгууллагын үр дүнг харахад ихэнх байгууллагын ил тод байдал өнгөрсөн онтой харьцуулахад өсжээ (Хүснэгт 3).

Эдгээр байгууллагуудаас Тохируулагч агентлагийн үр дүн өнгөрсөн онтой харьцуулахад буурсан бол бусад төрлийн байгууллагын үр дүн өссөн байна. Яамдын хувьд жигд сайн үнэлэгдсэн ба Барилга, хот байгуулалтын яам нийт байгууллагуудаас тэргүүлж (76.8%), хоёрт Сангийн яам (75.3%), гуравт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (74.7%) эрэмбэлэгдлээ.

2021 оны цахим ил тод байдлын индексээр Өвөрхангай аймгийн ЗДТГ 76.6%-тай тэргүүлж байсан бол 2022 онд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна. Сүүлийн 2 жилд тэргүүлсэн байгууллагын индексийн

түвшнийг харьцуулбал ижил түвшинд байна. Нийт аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ил тод байдал 'сул' түвшнээс 'хангалттай' түвшинд дээшилсэн нь 2021 оны индексээс хамгийн сайн өссөн үзүүлэлт болж байна. Үүнд нэлээд олон аймгийн ЗДТГ-ын цахим хуудаснууд шинэчлэгдэж, хэрэглэгчдэд илүү хялбар болсон байгаа нь нөлөөлсөн.

Хэдийгээр эхний байруудад ороогүй ч Гадаад харилцааны яам 15.7%-ийн өсөлт үзүүлж 'сул' түвшнээс 'хангалттай' түвшинд, Улсын бүртгэлийн ерөнхий газар (+17.8%), Сүхбаатар дүүргийн ЗДТГ (+17.1%), Төв аймгийн ЗДТГ (+15.4%)-уудын ил тод байдал өнгөрсөн онтой харьцуулахад хамгийн сайн өсөлттэй байж 'хангалтгүй' түвшнээс 'сул' түвшин рүү ахисан байна.

Бүрэлдэхүүн тус бүрээр нь харвал хэрэгжүүлэгч агентлагуудын бодлогын орчин хамгийн сайн, байгууллагын чадамжийн хувьд аймаг, нийслэлийн захиргаа хамгийн сайн, мэдээллийн цахим нээлттэй байдал яамдад хамгийн сайн байна.

Ерөнхийд нь дүгнэвэл бүхий л байгууллагын дундаж индекс 60 гаруй хувьтай, жигд байна. Байгууллагын төрөл тус бүрээр ангилсан эрэмбийг Хавсралт 2-оос харна уу.

ХҮСНЭГТ 3

Үр дүн, байгууллагын ангиллаар

#	Байгууллагын төрөл	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	2021 оны индекс	2022 оны индекс	Зөрүү
1	Монгол Улсын Яамд	79.6%	67.3%	53.0%	64.8%	66.6%	+1.8%
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	79.8%	65.8%	41.9%	59.5%	62.5%	+3.0%
3	Тохируулагч агентлагууд	78.0%	60.2%	45.4%	63.3%	61.2%	-2.1%
4	Аймгуудын ЗДТГ	78.2%	65.8%	42.1%	58.4%	61.4%	+3.0%
5	Дүүргүүдийн ЗДТГ	78.0%	70.7%	39.6%	61.2%	62.7%	+1.5%
6	Парламентын харьяа байгууллагууд	78.0%	68.1%	47.6%	59.7%	64.5%	+4.8%
	Ерөнхий дундаж	78.8%	66.2%	44.2%	60.2%	63.1%	+2.9%

3. Дүгнэлт, зөвлөмж

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс 63.1% буюу 'сул' түвшинд үнэлэгдсэн нь өнгөрсөн жилээс 2.9%-иар өссөн үзүүлэлт боловч сүүлийн 6 жилийн хугацаанд энэ ангилалд байсаар байна. Тиймээс төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшнийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зөвлөмжийг хүргэж байна.

Бодлогын орчин харьцангуй сайн бүрдэж, сүүлийн жилүүдэд бодлого, хуулиуд шинэчлэгдэн батлагдсаар байна. Ялангуяа цахим ил тод байдлыг хангах чиглэлээр төрөөс анхаарал хандуулж, тусдаа бүтэц бий болголоо. Гэвч эдгээр бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй болгохын тулд төрийн байгууллага тус бүрийн үүрэг, оролцоо, манлайлал чухал юм. Мониторингийн үр дүнгээс харахад төсөв хүрэлцээгүй, манлайлал хангалтгүй, хяналт сул учраас ил тод байдал дээшлэхгүй байна. Мэдээллийн ил тод байдлыг ихэнх тохиолдолд Шилэн дансны хуулийн хүрээнд харж, хэрэгжүүлж байгаа нь хэрэглэгчдэд хүртээмжгүй байхад нөлөөлж байна. Тиймээс байгууллага тус бүр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нээлттэй мэдээллийн хүрээ, хангах үйл явц, үүрэг хариуцлага, хяналтын механизм, нөөц зэргийг тусгасан баримт бичиг, журмыг дотооддоо баталж мөрдүүлэх хэрэгтэй.

Ихэнх төрийн байгууллагууд урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүддээ мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр заалт оруулж өгсөн боловч энэ нь аймгуудад иргэний танхимаар дамжуулан уулзалт, арга хэмжээ зохион байгуулах гэх мэт уламжлалт аргуудаар хязгаарлагдаж байна. Тиймээс мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд цахим арга хэрэгслүүдийг ашиглах талаар үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Батлагдсан баримт бичиг, журам, тушаал, шийдвэрүүд хэрэглэгчдэд хүртээмжгүй байна. Үүнд нөлөөлж буй хүчин зүйл нь тус баримт бичгүүдийг агуулгын дагуу нэрлэдэггүй тул түлхүүр үгээр хайж олоход хүндрэлтэй, батлагдсан актыг оруулсан хэр нь хавсралт баримт бичиг нь байхгүй, файлыг хадгалах, хуваалцах боломж муу зэрэг олон шалтгаан байна. Тиймээс цаашид цахимаар байршуулж буй бүх файлын мэдээллийг тодорхой нэрлэх, шаардлагатай бол дүрэм, журамд тусгаж албажуулах шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудын мэдээллийг ил тод болгох үүрэг бүхий албан хаагчтай болох байдал сайжирсан. Гэвч удирдлагаас олон нийтэд түгээх мэдээллийн цар хүрээг тодорхойлж, байгууллагын ажилтнуудад танилцуулах байдал сул байна. Тиймээс мэдээллийг ил тод болгох үйл явц хангалтгүй, мөн холбогдох албан хаагчдыг мэдээллээр хангах болон сургах үйл ажиллагаа хязгаарлагдмал байна. Мөн цахим хуудсаар иргэдтэй харилцах буюу хэрэглэгчдээс санал асуулга авах, өргөдөл, гомдол, санал хүсэлт авах зэрэгт дүн шинжилгээ хийж, үр дүнд тулгуурлан мэдээллийг ил тод болгоход чиглэсэн үйл ажиллагаанд тусгах, мэдээллийг ил тод болгохтой холбоотой мэдлэг, ур чадваруудыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Цахим хуудасны дизайн, технологийн шийдлүүд сайжирч байгаа боловч дотор нь байршуулж буй мэдээллийг ашиглахад хялбар байлгах тал дээр сайжруулах шаардлага байсаар байна. Тиймээс цахим хуудас доторх хайлтын системийг сайжруулах, хүссэн мэдээллээ хайх, хүлээн авахад хялбар байдлаар мэдээллийг байршуулахад анхаарах хэрэгтэй.

Ерөнхийд нь хэлбэл төрийн байгууллагууд мэдээллийг цахим хэлбэрээр байршуулахдаа ямар нэг холбогдох хууль тогтоомжийг хангах үүднээс байршуулж байгаа ба хэрэглэгчийн өнцгөөс тэдэнд мэдээлэл хайх, хүлээн авах

талаас нь бодолцон сайжруулах шаардлагатай юм. Тухайлбал, Шууд харилцах чатбот үйлчилгээг цахим хуудастаа нэвтрүүлэх, мэдээлэлд сэтгэгдэл бичих боломжтой болгох, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр онлайн санал хүсэлт авдаг болох зэргээр иргэдтэй харилцах боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ нь эгэх хариуцлагыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. Тиймээс тайланд зарим сайн байж болох жишээнүүдийг дурдаж оруулсан ба тэдгээрээс өөр хоорондоо суралцаж, сайжруулах боломж бүрдэх юм.

Мөн цахим хуудаст хандаж буй хүний тоог өдөр, сар улирал, жилээр харагддаг болгох хэрэгтэй. Энэ нь мэдээлэл хэр олонд хүрч байгаа, хэр хүртээмжтэй байгааг харах боломжийг бий болгоно. Байгууллага тус бүр дээрх хэрэглэгчдээс ирж буй сэтгэгдэл, санал хүсэлтүүд болон цахим хуудасны хандалтуудад жил, улирлаар шинжилгээ хийж, үр дүнг цахим мэдээллийн ил тод байдлыг сайжруулах үйл ажиллагаандаа тусгаж ажиллах нь байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Хавсралт 1. Арга зүй: Хэмжих индикаторууд, харгалзах оноо

Код	Индикаторууд	Дээд оноо
Е. Бодлогын орчин		57
E1. Мэдээлэл авах эрх (Олон улс)		8
E1.1	Мэдээлэл хүсэх эрх	2
E1.2	Мэдээллийн цар хүрээ	1
E1.3	Мэдээлэл хүсэх журам	1
E1.4	Татгалзал	1
E1.5	Гомдол гаргах	1
E1.6	Санкц ба хамгаалалт	1
E1.7	Таниулах арга хэмжээ	1
E2. Засаглал (Олон улс)		12
E2.1	Хуулийн хэрэгжилт	2
E2.2	Дуу хоолой ба хариуцлага	1
E2.3	Зохицуулалтын чанар	1
E2.4	Засгийн газрын үр нөлөөтэй байдал	1
E2.5	Төрийн төлөв байдал	4
E2.6	Төрийн үйл ажиллагаа	3
E3. Иргэний нийгэм (Олон улс)		15
E3.1	Иргэний оролцоо	2
E3.2	Хэвлэлийн эрх өлөө	1
E3.3	Иргэний нийгмийн төлөв байдал	1
E3.4	Цахим оролцоо	1
E3.5	Иргэний эрх чөлөөний хяналт (эрх зүйн)	1
E3.6	Засаглалд иргэдийг оролцуулах	4
E3.7	Эрх чөлөө	5
E4. Улсын түвшний бодлого, зохицуулалт		14
E4.1	Хууль, журам	5
E4.2	Бодлого төлөвлөлт	5
E4.3	Хэрэгжүүлэх субъект	3
E4.4	Хяналт тавих механизм	1
E5. Байгууллагын түвшний зохицуулалт		8
E5.1	Зохицуулалт	8
О. Байгууллагын чадамж		29
O1. Байгууллагын ил тод байдлыг хангах үйл явц ба нөөц		12
O1.1	Нөөцийн боломжит байдал	3
O1.2	Манлайлал	5
O1.3	Тасралтгүй сайжруулах чадавх	4
O2. Цахим хуудасны технологийн нийцтэй байдал		11
O2.1	Цахим хуудасны нийцтэй байдал	11
O3. МХТ-ийн чадавх		6
O3.1	МХТ-ийн чадавх	6
D. Цахим нээлттэй мэдээлэл		48
D1. Нээлттэй мэдээлэл		39
O1.1	Нөөцийн боломжит байдал	3
D1.1	Үйл ажиллагааны ил тод байдал	13
D1.2	Хүний нөөцийн ил тод байдал	9
D1.3	Төсөв, санхүүгийн ил тод байдал	10
D1.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	7
D2. Харилцаа холбоо ба эгэх холбоо		9
D2.1	Харилцаа ба эгэх холбоо	9
Нийт		150

Хавсралт 2. Байгууллагын төрөл тус бүрийн эрэмбэ

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Яамдын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Барилга, хот байгуулалтын яам	76.8%	80.0%	77.3%	73.1%
2	Сангийн яам	75.3%	80.0%	84.0%	61.9%
3	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	74.7%	82.0%	84.3%	57.9%
4	Цахим хөгжил харилцаа холбооны яам	71.0%	78.0%	74.3%	60.7%
5	Гадаад харилцааны яам	69.5%	82.0%	75.6%	50.8%
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	69.0%	78.0%	73.2%	55.8%
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.1%	82.0%	70.3%	46.1%
8	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	65.9%	78.0%	62.1%	57.5%
9	Эрчим хүчний яам	65.7%	80.0%	75.0%	42.2%
10	Батлан хамгаалах яам	65.2%	80.0%	64.9%	50.6%
11	Зам, тээврийн хөгжлийн яам	64.1%	80.0%	68.5%	43.8%
12	Соёлын яам	63.1%	78.0%	55.6%	55.8%
13	Эрүүл мэндийн яам	62.0%	78.0%	61.0%	46.9%
14	Хууль, зүй дотоод хэргийн яам	60.2%	80.0%	52.2%	48.3%
15	Боловсрол, шинжлэх ухааны яам	59.3%	80.0%	51.1%	46.9%
16	Эдийн засаг, хөгжлийн яам	58.3%	78.0%	46.6%	50.3%
Яамдын индекс		66.6%	79.6%	67.3%	53.0%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.5%	78.8%	66.2%	44.2%

Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	66.5%	78.0%	72.2%	49.2%
2	Цагдаагийн ерөнхий газар	65.6%	78.0%	64.8%	53.9%
3	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	64.3%	78.0%	70.2%	44.5%
4	Онцгой байдлын ерөнхий газар	64.1%	78.0%	60.5%	53.9%
5	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	63.5%	78.0%	72.0%	40.6%
6	Стандарт, хэмжил зүйн газар	63.1%	78.0%	66.0%	45.3%
7	Зэвсэгт хүчний жанжин штаб	61.5%	78.0%	67.3%	39.1%
8	Тагнуулын ерөнхий газар	59.5%	78.0%	53.0%	47.6%
9	Хил хамгаалах ерөнхий газар	54.7%	78.0%	43.9%	42.2%
10	Төрийн тусгай хамгаалалтын газар	49.1%	78.0%	31.9%	37.5%
Тохируулагч агентлагийн индекс		61.2%	78.0%	60.2%	45.4%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	72.6%	78.0%	79.8%	59.8%
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	70.1%	80.0%	74.4%	56.0%
3	Татварын ерөнхий газар	70.1%	82.0%	74.4%	53.9%
4	Төрийн худалдан авах ажиллагааны газар	69.5%	80.0%	88.0%	40.6%
5	Архивын ерөнхий газар	67.1%	80.0%	78.4%	43.0%
6	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	67.1%	80.0%	76.0%	45.3%
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	67.0%	78.0%	67.4%	55.5%
8	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	65.9%	82.0%	81.4%	34.4%
9	Усны газар	65.8%	80.0%	74.5%	43.0%
10	Оюуны өмчийн газар	65.7%	78.0%	77.0%	42.2%
11	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	63.3%	78.0%	67.3%	44.5%
12	Гадаадын иргэн, харьяатын газар	63.1%	78.0%	69.0%	42.2%
13	Жижиг, дунд үйлдвэрийн газар	63.0%	78.0%	68.0%	43.0%
14	Улсын бүртгэлийн ерөнхий газар	62.8%	82.0%	62.8%	43.8%
15	Үндэсний геологийн алба	61.9%	82.0%	63.2%	40.6%
16	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	61.7%	78.0%	67.3%	39.8%
17	Цаг уур, орчны шинжилгээний газар	61.1%	82.0%	61.6%	39.8%
18	Боловсролын ерөнхий газар	59.5%	78.0%	63.0%	37.5%
19	Иргэний нисэхийн ерөнхий газар	59.4%	82.0%	57.2%	39.1%
20	Ашигт малтмал, газрын тосны газар	59.1%	82.0%	55.3%	39.8%
21	Соёл, урлагийн газар	58.2%	78.0%	55.2%	41.4%
22	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	57.9%	82.0%	44.8%	46.9%
23	Гаалийн ерөнхий газар	57.1%	82.0%	52.5%	36.7%
24	Биеийн тамир, спортын улсын хороо	56.7%	80.0%	49.4%	40.6%
25	Нийгмийн даатгалын ерөнхий газар	56.1%	78.0%	51.2%	39.1%
26	Мал эмнэлгийн ерөнхий газар	43.5%	78.0%	52.5%	
Хэрэгжүүлэгч агентлагийн индекс		62.5%	79.8%	65.8%	41.9%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Аймгийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Өвөрхангай аймаг	74.6%	78.0%	86.6%	59.2%
2	Говьсүмбэр аймаг	65.5%	78.0%	77.9%	40.6%
3	Өмнөговь аймаг	64.9%	78.0%	63.2%	53.4%
4	Увс аймаг	64.4%	78.0%	76.0%	39.1%
5	Төв аймаг	64.3%	78.0%	80.6%	34.4%
6	Дархан-Уул аймаг	64.3%	78.0%	72.6%	42.2%
7	Баянхонгор аймаг	63.9%	78.0%	71.4%	42.2%
8	Улаанбаатар хотын захирагчийн алба	63.4%	82.0%	73.0%	35.2%
9	Булган аймаг	63.0%	78.0%	59.3%	51.6%
10	Хөвсгөл аймаг	62.2%	78.0%	71.1%	37.5%
11	Орхон аймаг	61.5%	78.0%	54.9%	51.6%
12	Баян-Өлгий аймаг	61.4%	78.0%	68.6%	37.5%
13	Хэнтий аймаг	59.6%	78.0%	61.7%	39.1%
14	Сүхбаатар аймаг	59.5%	78.0%	63.0%	37.5%
15	Дорноговь аймаг	59.5%	78.0%	59.0%	41.4%
16	Дундговь аймаг	58.2%	78.0%	55.3%	41.4%
17	Завхан аймаг	58.0%	78.0%	56.1%	39.8%
18	Ховд аймаг	57.6%	78.0%	53.3%	41.4%
19	Архангай аймаг	57.2%	78.0%	93.5%	
20	Сэлэнгэ аймаг	57.0%	78.0%	51.7%	41.4%
21	Дорнод аймаг	55.8%	78.0%	52.7%	36.7%
22	Говь-Алтай аймаг	54.9%	78.0%	45.2%	41.4%
Аймаг, нийслэлийн дундаж		61.4%	78.5%	75.2%	43.3%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Дүүргийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Багануур дүүрэг	67.1%	78.0%	81.0%	42.2%
2	Хан-Уул дүүрэг	66.8%	78.0%	78.7%	43.8%
3	Чингэлтэй дүүрэг	66.2%	78.0%	83.1%	37.5%
4	Сонгинохайрхан дүүрэг	65.4%	78.0%	73.8%	44.5%
5	Баянгол дүүрэг	64.4%	78.0%	73.1%	42.2%
6	Баянзүрх дүүрэг	63.7%	78.0%	62.3%	50.8%
7	Налайх дүүрэг	60.3%	78.0%	47.5%	55.5%
8	Сүхбаатар дүүрэг	59.6%	78.0%	61.0%	39.8%
9	Багахангай дүүрэг	51.2%	78.0%	75.5%	
Дүүргүүдийн дундаж		62.7%	78.0%	70.7%	39.6%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдал

#	Байгууллагууд	Цахим ил тод байдлын индекс	Бодлогын орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Монгол Банк	70.7%	78.0%	71.5%	62.7%
2	Санхүүгийн зохицуулах хороо	66.7%	78.0%	59.2%	62.8%
3	Жендерийн үндэсний хороо	66.6%	78.0%	78.2%	43.8%
4	Үндэсний аудитын газар	66.4%	78.0%	82.1%	39.1%
5	Авлигатай тэмцэх газар	66.4%	78.0%	75.0%	46.1%
6	Монгол Улсын Их Хурал	65.2%	78.0%	76.3%	41.4%
7	Сонгуулийн ерөнхий хороо	63.7%	78.0%	62.3%	50.8%
8	Үндэсний статистикийн хороо	63.1%	78.0%	62.2%	49.2%
9	Хүний эрхийн үндэсний комисс	59.7%	78.0%	60.3%	40.6%
10	Төрийн албаны зөвлөл	56.8%	78.0%	53.3%	39.1%
Парламентын харьяа байгууллагын индекс		64.5%	78.0%	68.1%	47.6%
Улсын цахим ил тод байдлын индекс		63.1%	78.8%	66.2%	44.2%

Хавсралт 3. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ

Сайн | >80 | Хангалттай | 65-79 | Сул | 50-64 | Хангалтгүй | 35-49 | Муу | <35

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2021 оны индекс	Өөрчлөлт
1	Барилга хот байгуулалтын яам	76.8%	68.4%	8.4%
2	Сангийн яам	75.3%	72.4%	2.9%
3	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам	74.7%	71.3%	3.4%
4	Өвөрхангай аймаг	74.6%	76.6%	-2.0%
5	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	72.6%	69.8%	2.8%
6	Цахим хөгжил харилцаа холбооны яам*	71.0%	-	
7	Монгол Банк	70.7%	68.0%	2.7%
8	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	70.1%	63.5%	6.6%
8	Татварын ерөнхий газар	70.1%	65.4%	4.7%
9	Төрийн худалдан авах ажиллагааны газар	69.5%	61.6%	7.9%
9	Гадаад харилцааны яам	69.5%	53.8%	15.7%
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	69.0%	65.8%	3.2%
11	Архивын ерөнхий газар	67.1%	64.5%	2.6%
11	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	67.1%	59.6%	7.5%
11	Багануур дүүрэг	67.1%	67.0%	0.1%
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	67.0%	70.3%	-3.3%
13	Хан-Уул дүүрэг	66.8%	74.7%	-7.9%
14	Санхүүгийн зохицуулах хороо	66.7%	65.7%	1.0%
15	Жендерийн үндэсний хороо	66.6%	64.8%	1.8%
16	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	66.5%	61.6%	4.9%
17	Үндэсний аудитын газар	66.4%	58.5%	7.9%
17	Авлигатай тэмцэх газар	66.4%	67.0%	-0.6%
18	Чингэлтэй дүүрэг	66.2%	51.0%	15.2%
19	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	66.1%	61.5%	4.6%
20	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	65.9%	53.5%	12.4%
20	Байгаль орчин аялал жуулчлалын яам	65.9%	63.8%	2.1%
21	Усны газар	65.8%	68.6%	-2.8%
22	Эрчим хүчний яам	65.7%	57.5%	8.2%
22	Оюуны өмчийн газар	65.7%	59.4%	6.3%
23	Цагдаагийн ерөнхий газар	65.6%	69.2%	-3.6%
24	Говьсүмбэр аймаг	65.5%	61.8%	3.7%
25	Сонгинохайрхан дүүрэг	65.4%	63.9%	1.5%
26	Монгол Улсын Их Хурал*	65.2%	-	
26	Батлан хамгаалах яам	65.2%	62.5%	2.7%
27	Өмнөговь аймаг	64.9%	72.0%	-7.1%
28	Баянгол дүүрэг	64.4%	62.5%	1.9%
28	Увс аймаг	64.4%	59.1%	5.3%
29	Төв аймаг	64.3%	48.9%	15.4%
29	Дархан-Уул аймаг	64.3%	67.3%	-3.0%
29	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	64.3%	59.6%	4.7%
30	Онцгой байдлын ерөнхий газар	64.1%	68.8%	-4.7%
30	Зам, тээврийн хөгжлийн яам	64.1%	65.1%	-1.0%
31	Баянхонгор аймаг	63.9%	53.1%	10.8%
32	Баянзүрх дүүрэг	63.7%	68.5%	-4.8%

Эрэмбэ	Байгууллагууд	2022 оны индекс	2021 оны индекс	Өөрчлөлт
32	Сонгуулийн ерөнхий хороо	63.7%	64.7%	-1.0%
33	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	63.5%	59.7%	3.8%
34	Улаанбаатар хотын захирагчийн алба	63.4%	49.7%	13.7%
35	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	63.3%	50.9%	12.4%
36	Үндэсний статистикийн хороо	63.1%	59.3%	3.8%
36	Соёлын яам	63.1%	58.5%	4.6%
36	Стандарт, хэмжил зүйн газар	63.1%	59.2%	3.9%
36	Гадаадын иргэн, харьяатын газар	63.1%	50.7%	12.4%
37	Жижиг, дунд үйлдвэрийн газар	63.0%	54.9%	8.1%
37	Булган аймаг	63.0%	68.0%	-5.0%
38	Улсын бүртгэлийн ерөнхий газар	62.8%	45.0%	17.8%
39	Хөвсгөл аймаг	62.2%	66.0%	-3.8%
40	Эрүүл мэндийн яам	62.0%	61.3%	0.7%
41	Үндэсний геологийн алба	61.9%	54.9%	7.0%
42	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар*	61.7%	-	
43	Орхон аймаг	61.5%	66.1%	-4.6%
43	Зэвсэгт хүчний жанжин штаб	61.5%	53.5%	8.0%
44	Баян-Өлгий аймаг	61.4%	57.9%	3.5%
45	Цаг уур, орчны шинжилгээний газар	61.1%	50.7%	10.4%
46	Налайх дүүрэг	60.3%	65.4%	-5.1%
47	Хууль, зүй дотоод хэргийн яам	60.2%	60.6%	-0.4%
48	Хүний эрхийн үндэсний комисс	59.7%	45.5%	14.2%
49	Сүхбаатар дүүрэг	59.6%	42.5%	17.1%
49	Хэнтий аймаг	59.6%	60.2%	-0.6%
50	Тагнуулын ерөнхий газар	59.5%	50.9%	8.6%
50	Боловсролын ерөнхий газар*	59.5%	-	
50	Сүхбаатар аймаг	59.5%	47.9%	11.6%
50	Дорноговь аймаг	59.5%	50.1%	9.4%
51	Иргэний нисэхийн ерөнхий газар	59.4%	63.9%	-4.5%
52	Боловсрол шинжлэх ухааны яам	59.3%	60.0%	-0.7%
53	Ашигт малтмал, газрын тосны газар	59.1%	55.8%	3.3%
54	Эдийн засаг, хөгжлийн яам*	58.3%	-	
55	Дундговь аймаг	58.2%	50.1%	8.1%
55	Соёл, урлагийн газар	58.2%	52.4%	5.8%
56	Завхан аймаг	58.0%	56.3%	1.7%
57	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	57.9%	60.3%	-2.4%
58	Ховд аймаг	57.6%	60.3%	-2.7%
59	Архангай аймаг	57.2%	52.5%	4.7%
60	Гаалийн ерөнхий газар	57.1%	53.7%	3.4%
61	Сэлэнгэ аймаг	57.0%	48.9%	8.1%
62	Төрийн албаны зөвлөл	56.8%	59.6%	-2.8%
63	Биеийн тамир, спортын улсын хороо	56.7%	59.8%	-3.1%
64	Нийгмийн даатгалын ерөнхий газар	56.1%	56.9%	-0.8%
65	Дорнод аймаг	55.8%	52.9%	2.9%
66	Говь-Алтай аймаг	54.9%	57.2%	-2.3%
67	Хил хамгаалах ерөнхий газар	54.7%	52.1%	2.6%
68	Багахангай дүүрэг	51.2%	45.6%	5.6%
69	Төрийн тусгай хамгаалалтын газар	49.1%	54.5%	-5.4%
70	Мал эмнэлгийн ерөнхий газар	43.5%	49.0%	-5.5%

* Шинээр байгуулагдсан болон өмнөх жилд хамрагдаагүй байгууллагууд